

## ГАРЧИГ

Д.Д	НЭР	ХУУДАСНЫ ДУГААР
1	<b>ГЕОЛОГИЙН СУДАЛГАА</b>	2
2	<b>УУРХАЙН ХИЛ ХЯЗГААР, ОРДЫН НӨӨЦИЙН ТООЦОО</b>	9
3	<b>УУРХАЙН ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ, АШИГЛАХ ХУГАЦАА</b>	9
4	<b>УУРХАЙН ТАЛБАЙГ АШИГЛАХ ДАРААЛАЛ, АШИГЛАЛТЫН СИСТЕМ</b>	10 10
5	<b>ДЭД БҮТЭЦ БА БУСАД ПРОЦЕССУУД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭЛТ</b>	11 13
6	<b>ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b>	14
8	<b>БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	18
9	<b>УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС</b>	25

## I. ГЕОЛОГИЙН СУДАЛГАА


### 1.1. Ордын тухай өрөнхий мэдээлэл

Газарзүйн байршил: “Бөхөгийн хөндий” баруун хойт хэсгийн элс, хайрганы холимгийн ордын талбай нь Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт байрлана.

- Засаг захиргаа: Төв аймаг, Алтанбулаг сум
- Талбайн нэр: “Бөхөгийн хөндий”
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Элс хайрганы холимог
- Трапецийн номенклатур: L-48-10
- Талбайн нийт хэмжээ: 17.52 га

Хүснэгт 1. Талбайн газар зүйн байршил, солбицол

№	Үртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	Минут	секунд
1	106	36	39.2	47	43	8
2	106	36	39.2	47	43	32
3	106	36	35.72	47	43	91
4	106	36	36.12	47	43	52
5	106	36	39.2	47	44	0.95
6	106	36	39.2	47	44	5.78
7	106	36	16.3	47	44	5.78
8	106	36	16.3	47	43	56.18
9	106	36	17.01	47	43	56.17
10	106	36	19.07	47	43	55.96
11	106	36	21.09	47	43	55.6
12	106	36	22.86	47	43	55.15
13	106	36	24.31	47	43	54.66
14	106	36	37.38	47	43	48.8



**Уул зүй:** Монгол орны физик газарзүйн мужлалтаар Төв аймгийн Алтанбулаг сум нь Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужид хамаарах ба салбар уулсын бэлийн бэсрэг уулс, ухаа толгодоор хүрээлэгдэнэ. Энэ дүүргийн дунд зэргийн өндөрлөгтэй бэсрэг уулс нь идэгдэлд орсон эгц хажуу шовх оройтой, хадан гарш, гуу жалга ихтэй. Талбайн зүүн хойд, баруун хэсгээр жижиг толгодлог болон хөндий бүхий нам уулсын гадаргуу зонхилох бөгөөд тэдгээр нь ерөнхийдөө баруун, баруун хойш чиглэлд сунаж тогтсон байдаг. Баруун урд болон баруун талаар урсах Бөхөг гол, Туул голын хөндий нь нилээд өргөн бөгөөд томоохон тэвш хэлбэртэй тэгшивтэр гадаргуутай аллювийн хөндийгөөс дээшлэхэд налуувтар гадаргууд шилжиж пролювийн дэнж үүсгэнэ.

Ойролцоо хамгийн өндөр цэг нь талбайн зүүн талд орших 1305.0 м тоот өндөрлөг, хамгийн нам дор цэг нь Туул голын хөндийд 1203.0 м байна. Гадаргуутын гарш илэрцийн хувьд дунд зэргийн төлөв байдалтай.

**Ус зүй:** Бөхөгийн хөндийн баруун хойт хэсгийн элс хайрганы холимогийн орд” төслийн талбай нь Туул голын сав газарт байрлаж байна.

Туул гол нь 6 дугаар эрэмбийн гол юм. Хан Хэнтийн нурууны салбар уулс болох далайн түвшнээс дээш 2000 м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намъяа, Нэргүй хэмээх хоёр голын уулзвараас эх авна. Голын ус хурах талбай 449774.3 ам км, хэвгий 0.0015 юм.

**Уур амьсгал:** Төслийн обьектийн ойр орших цаг уурын Алтанбулаг өртөөний олон жилийн ажиглалтын мэдээг баримталж бичив. Цаг уурын Алтанбулаг өртөө

хойд өргөргийн 47038`, зүүн уртрагийн 105025`-д далайн түвшнээс 1260 м-ийн өндөрт оршино. Цаг уурын Алтанбулаг өртөө 1997 оны 6 дугаар сарын 1 -нд байгуулагдсан бөгөөд түүнээс өмнө цаг уурын харуул хэлбэрээр ажиллаж байсан байна. Гэхдээ цаг уурын Алтанбулаг өртөө цөөхөн жил ажилласан учир уур амьсгалын олон жилийн зарим өгөгдлийг ойролцоо орших Буянт Ухаагаар авсан болно. Төслийн район жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа урт, агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзлэл ихтэй, хур тунадас бага, үүлшил, агаарын чийгшил багатай эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг.

**Хөрс:** Бөхөгийн хөндий” баруун хойт хэсгийн элс хайрганы холимогийн орд газрын орчмын хөрс нь байгалийн бүс бүслүүрийн хувьд Уулт ойт хээрийн уулын ойн саарал ба уулын хээрийн хүрэн хөрсний бүслүүр, тал хээрийн хүрэн хөрсний бүслүүр, хөрс-газарзүйн мужлалаар тал хээрийн хөндийн хүрэн хөрс, хүрэн хөрсний мужлалд багтах бөгөөд хөрсөн бүрхэвчийн хувьд цайвар хүрэн хөрс зонхилсон нутагт хамрагдана. Энэ районд хээрийн бүслүүр нэн түгээмэл хөгжиж бэсрэг уул нурууны бэл хормойгоос эхлэн дээд биеийг хүртэл ихээхэн талбайг эзлэн тархана. Уулын хээрийн бүрэлдэхүүнд алаг өвс, малд идэгддэггүй шарилж бага зэрэг тархсан бөгөөд үетэн голлоно. Уулын хээрийн бүслүүрийн доод захаар цөлөрхөг хээрийн бор, цайвар хүрэн хөрс хаялж тархах бөгөөд түүнээс дээш уулын хүрэн, уулын хар шороон, уулын хээрийн хөрс дараалан тархана. Уулсын орой хяр, энгэр хажууд чулуурхаг, чулуун асгарга бага зэрэг тархсан байдаг учир хөрсөн бүрхэвч жигд тогтвожиж чадаагүй байдаг.

**Амьтан ургамал:** Энэ бүс нутагт олон салаа гүн нүх малтан орогнож голдуу ногоон өвсөөр хооллодог мэрэгчид зонхилно. Тэдгээрийн тоонд өвөл ичдэг тарвага, жилийн турш идэвхтэй, хөдөлгөөнтэй байдаг жижиг амьтад орно. Зарим зүйлийн мэрэгчид хэт олширсноос болж хөрс, ургамалд сөрөг нөлөө үзүүлдэг. Шувуудын хувьд өвөл цас багатай, нарлаг өдөр олон учраас зөвхөн нутгийн суурин шувууд төдийгүй умард тундрын шувууд ч өвөлжих аятай нөхцөл бүрддэг байна. Хүнд ойр оршдог шувууд ч олон бий. Энэ бүлэгт хэрээ, улаан хошуут, хадны тагтаа, сохор элээ, үхэр цахтай зэрэг орно.

Эх газрын гандуу уур амьсгалын нөлөөгөөр хуурайсаг болон нуугдамхай хэлбэрийн шавьж, ялангуяа авгалдайн шатандаа далд газар амьдралтай шавьж элбэг байдаг байна.

**Хүн ам, эдийн засаг, зам харилцаа:** “Пирамид прогресс” ХХК -ийн “Бөхөгийн хөндийн баруун хойт хэсгийн элс хайрганы холимогийн орд” талбай нь Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт оршино.

## 1.2. Геологийн судалгааны товч түүх

Тус бүс нутгийн газар зүйн байдал ба геологийн тогтоцын талаархи анхны мэдээлэл нь өнгөрсөн зууны 1920-оод оноос эхлэлтэй юм. 1925 онд ЗХУ-ын Шинжлэх Ухааны Академи, БНМАУ-ын Шинжлэх Ухааны Хорооны хооронд хамтарсан экспедицүүд байгуулагдан судалгаа, шинжилгээний ажлыг эхлэн хийсэн байна.

1930 онд БНМАУ-ын Засгийн газрын хүсэлтээр ЗХУ-ын ШУА-ийн ажилтан З.А.Лебедев Улаанбаатар хот түүний дүүрэгт 1:1000000-н масштабтай геологийн зураглалын ажлыг хийжээ. Дээрхи зураглалын ажлын гол зорилго нь Улаанбаатар хот орчимд барилгын материалын түүхий эдийн орд илрэлүүдийг олж тогтооход чиглэгдсэн байна.

1940 оноос геологийн судалгааг талбайн шинжтэй явуулж эхэлсэн бөгөөд районы геологийн тогтоцын талаар янз бүрийн төсөөлөлүүдийг дэвшүүлэн тавьж байсан боловч давхарга зүйн талаар нэгдсэн нэг ойлголтонд нилээд хожим болтол хүрч чадаагүй юм.

1944 онд талбайг бараг бүхэлд нь хамарсан хэсэгт Ю.С.Желубовский, М.А.Анпилов нарын удирдлагаар 1:200000-ны масштабын геологийн зураглалын ажил явуулж дунд эрт төрмөлийн элсжин, шаварлаг болон бусад занарууд, хөрзөн, шохойжин, хас, кварцит, хувирマル бялхмал чулуулгаас бүрдэх элсжин- занарын зузаалгийг деван, карбоны насанд хамааруулжээ.

Мөн доод цэrdийн үеийн нүүрс агуулагч, дээд цэrdийн тунамал, дөрөвдөгчийн хурдсуудыг ялгаж зузааныг нь тогтоожээ.

1951 онд М.Г.Королевийн хийсэн 1:200000-ын масштабын геологийн зураглалын ажил талбайн зүүн ба урд талыг хамардаг ба дунд-дээд эрт төрмөлийн тунамал-хувирマル хурдсыг нарийн судалтай хлоритжсон занар (2000 м), шаварлаг занар (4500 м), элсжин (5500 м) гэсэн 3 зузаалагт хуваан томоохон талбайд ялгажээ.

1958 онд Г.С.Катковский, В.В.Беззубцев нар талбайн зүүн хойт өнцөгт 1:200000-ын масштабын геологийн зураглалын ажил хийж элсжин занарын серийг девоны насанд хамруулж дотор нь 4 зузаалаг ялгажээ.

1959 онд Ю.А.Арсентьев, В.А.Ботезату нар талбайн зүүн хойт хэсгээр 1:1000000-н масштабын геологийн зураглалын ажил явуулж Улаанбаатарын бүс нь

девоны болон силурын хурдаар хучигдсан дунд-дээд эрт төрмөлийн настай антиклиналь бүтэц байна гэж тэмдэглэжээ.

1960 онд геологич Н.В.Чернышев Улаанбаатар хот орчмын талбайд барилгын чулуу, тоосгоны шаврын эрлийн ажил хийж, Тахилтын тоосгоны шавар, Бэлх, Цагаан давааны барилгын чулууны илрэлүүдийг олж тогтоосон бөгөөд улмаар 1961 онд геологич П.Г.Медведьев урьдчилсан хайгуул хийж нөөцийг тогтоосон байна.

1961 онд В.А.Варламов, М.С.Богусловский нар талбайн хойт хэсгээр 1:1000000-ны масштабын геологийн зураглалын ажил хийж граувакийн серийн хурдсыг дээд эхэн төрмөл- доод кембрийн настай гэж үзсэн нь Хэнтий нурууны эртний төрмөлийн хурдасны судалгаанд цоо шинэ санаа дэвшүүлсэн байна.

1966-1967 онуудад Л.Гомбосүрэн, Б.Жамбаа нар Улаанбаатар хот орчмын болон ордын дүүргийн геологийн тогтоцыг 1:200000-ны зураглалын ажлаар нарийвчлан тогтоосон байдаг юм. 1955 онд геологич Е.Е.Сыклын Улаанбаатар хотын дүүрэгт тоосгоны шаврын ордын эрэл- хайгуулын ажлыг тэр үед ажиллаж байсан Толгойтын ба Улаанхуарагийн тоосгоны заводын орчмын талбайд хийсэн байна.

Энэ ажлын үр дүнгээр Баянхошууны зүүн салаа голын зүүн эрэгт орших Толгойтын тоосгоны шаврын орд, Хужирбулан, Цагаан давааны тоосгоны шаврын ордуудыг нээн илрүүлж хайгуул судалгаа хийжээ.

1990 онд Геологийн Эрдэс Баялгийн Хүрээлэнгийн ажилтнууд доктор О.Төмөртогоогийн удирдлагаар Төв ба Зүүн Монголын 1:500 000-ны масштабтай геологийн зураг зохиож түүний тайлбар бичгийг хавсаргажээ.

1990-1992 онд Т.Өнөдэлгэр, Д.Банзрагч нарын Улаанбаатар хот орчим талбайд 1:50000-ны масштабтай гидрогеологи, агаарын геофизик, геофизик, геохимиийн судалгааны иж бүрдэл эрлийн ажлыг явуулжээ. Энэ ажил нь тус дүүргийн геологийн тогтоц, геофизик, геохимиийн гажилуудын онцлогийг хамгийн сүүлийн үеийн мэдээлэлийг ашиглан иж бүрэн аргачлалаар судлан нэгтгэн дүгнэсэн байна.

Ордын дүүрэгт 1973 оноос хойшхи хугацаанд барилгын материалын түүхий эдийн чиглэлээр судалгааны ажил нилээд эрчимтэй хийгдэж ирсэний үр дүнд: Улаанбаатар, Улаанбаатар-II, Сонгины Гишүүний амны, Бөхөг голын, дунд Бөхөгийн элс-хайрганы, Шувуун фабрик, Биокомбинатын элсний, Толгойтын керамик шаврын түүхий эдийн ордуудын хайгуулын ажлыг амжилттай хийж нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр тус тус батлуулсан байна.

### **1.3. Судалгааны талбай болон ордын геологийн тогтоц**

Тус дүүргийн геологийн тогтоцыг янз бүрийн цаг хугацаанд судалгааны өөр өөр түвшинд өмнө нь олон судлаачид судалж иржээ.

Судалгааны талбай нь Хойт Монголын атриат мужийн Хэнтийн синклиниорийн Улаанбаатарын варисцидын хотгорын хэмжээнд оршдог. Тусгай зөвшөөрөл бүхий талбайн хэмжээнд доод-дээд карбоны элсжин-занарын, алевролит-элсжингийн 2 зузаалаг, дээд карбоны элсжин зонхилсон зузаалгууд ба дөрөвдөгчийн цаг үед хуримтлагдсан эх газрын тунамал хурдсууд тархсан байдаг.

#### **1.3.1. Давхарга зүй.**

Судалгааны талбайн хэмжээнд тунамал хувирмал хурдсаас карбоны тунамал болон эх газрын уулс хоорондын давхацмал хотгоруудад хуримтлагдсан тунамал молассын гарал үүсэлтэй дунд ба шинэ төрмөлийн хучаас хурдсууд тархдаг.

### **1.4. “Доод Бөхөгийн хөндий” элс-хайрганы холимогийн ордын геологийн тогтоц**

“Доод Бөхөгийн хөндий” элс-хайрганы холимогийн орд нь Туул голын хөндийд дөрөвдөгчийн хурдас тархсан талбайн зүүн хаяа Бөхөгийн хөндийн баруун хэсэгт оршино. Энэ ордын газрын гадаргуу тэгшивтэр хэсгээр нь алювиин гаралтай хурдас, зүүн хэсгээрээ газрын гадаргуу харьцангуйгаар өндөрсөж зүүн талын уулын баруун бэл хажуу болж делюв-пролювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдас тус тус тархаж эдгээр сэвсгэр хурдасуудыг салхины гаралтай элсний үеэр хучиж тогтсон байна.

Талбайн геологийн тогтоцыг судлах, ашигт малтмалын чанарын тодорхойлолт өгөх зорилгоор хайгуулын 2 шугам тавьж хайгуулын шурфүүдээр нэвтрэлт хийсэн бөгөөд малтальтын геологийн анхан шатны материалыг үндэслэн ордын геологийн тогтоцыг тодорхойлов.

Талбайн хэмжээнд делюви-пролювийн гарал үүсэлтэй элс-дайрга-хэмхдэсийн холимог хурдас тархажээ. Энэ 2 хурдасны хил зааг газрын гадаргуугын түвшингийн өөрчлөлтөөр шууд ялгагдаж байна.

Хээрийн судалгаагаар дайрганы ихэнх хэсэг нь (95% дээш) элсэн чулуугаас бүрдэнэ. Хэмхдэс-хайрга нь дунд зэргийн мөлгөржсөн, хавтгайллаг, үзүүрлэг шөвгөр хэсэг байна. Тоос шавар ба шорооны хольцын хэмжээ 0.4%, элсэнд агуулагдах уулын чулуулгийн хэмхдэс болон хайрганы хэмжээ 1.3-21.3% -ийн агуулгатай байна.

Энэ шинжилгээний үр дүнгээс хараад элс нь дунд, том ширхэгтэй элсэнд хамарагдана. Энэ хурдасанд хөрсний ус илрээгүй хуурай байсан.

## 1.5. Гидрогеологи

Өмнөх судлаачид судалгааны дүүрэгт 1:50000 масштабтай эрэл зураглалын ажлыг хийсэн байна. Уг ажлын үр дүнд судалгааны талбайн хэмжээнд геологийн тогтоц давхарга зүйн байдлыг үндэслэн, доор дурдсан уст цогцолбор үе давхарга болон газар доорх усны бусад хурумтлал бөөгнөрлийг ялгасан байна. (Т.Өнөдэлгэр, Д.Банзрагч, 1990-1992)

## 1.6. Геоморфологи

Судалгааны талбай нь Туул голын дунд хэсэг, Бөхөг, Түргэний гол болон тэдгээрийн бэлчирийн доод хэсэгт хамрах дунд зэргийн уулархаг мужид хамаарна. Талбайн хамгийн өндөр цэг нь “Ташгай” талбайн зүүн урд орших “Жиргагч” уул 1737.3 м, хамгийн нам дор цэг нь туул голын хөндийд 1203.0 м-ийн харьцаангуй өндөржилттэй Туул голын хөндий болно. Ордын дүүргийг гадаргуугийн байдлаар нь:

- а/ Тектоник-денудацийн
- б/ Элэгдэл-хурумтлалын гэсэн морфологийн төрлүүдэд хувааж болох юм.

Судалгааны талбайн бүхэлдээ нүүцэн үндсэн чулуугийн бүрхэвчтэй тул хөрсний элэгдэлд бага өртөж харин жалга, судгуудаар түр зуурын усны үйлчлэлээр элэгдэлд автсан байdag.

## 1.7. Ашигт малтмал

Судалгааны дүүрэг ба талбайд илрэгдсэн гол үйлдвэрлэлийн ач холбогдолтой ашигт малтмалын төрөл нь барилгын материалын түүхий эдийн ордууд байдаг ба өөр төрлийн ашигт малтмалын орд багаар тохиолдоно.

1960 онд геологич Н.В.Чернышев Улаанбаатар хот орчмын талбайд эрлийн ажил хийснээр Тахилтын амны тоосгоны шаврын ордыг илрүүлсэн ба энэ ордод 1961 онд геологич Н.Г.Медведьев урьдчилсан хайгуул хийж нөөцийг  $581.2 \text{ мян}/\text{м}^3$  гэж тооцсон.

1966 оноос хойш тус дүүрэгт барилгын материалын түүхий эдийн чиглэлээр судалгааны ажил нилээд эрчимтэй хийгдэж ирсэний үр дүнд: Улаанбаатар, Улаанбаатар-II, Сонгины гишүүний амны, Бөхөг голын, дунд Бөхөгийн элс хайрганы хольцын, Биокомбинат, Шувуун фабрикийн элсний, Толгойтын керамикийн түүхий эдийн зэрэг ордуудын хайгуулын ажлыг амжилттай хийж нөөцийг үйлдвэрийн зэргээр тус тус батлуулсан байdag.

**II. УУРХАЙН ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ,  
АЖИЛЛАХ ГОРИМ, АШИГЛАХ ХУГАЦАА**

**2.1. Уурхайн жилийн хүчин чадал**

Уурхайн хүчин чадлыг төсөл захиалагч компанийн даалгаврын дагуу жилд 250.0 мян.м<sup>3</sup> элс-хайрганы холимог олборлоо ТЭЗҮ-г боловсруулсан.

**2.2. Уурхайн ажиллах горим**

Уурхай нь 4-р сарын 1- нээс 11-р сарын 1 хүртэл 7 сар ажиллана.

Тус уурхай нь жилийн баяр ёслолын өдрүүдээс бусад бүх өдрүүдэд ажиллана.

Жилд ажиллах хоногийн тоо:

- Жилийн нийт ажиллах хоног - 214
- Баяр ёслолын хоног - 4
- Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд зарцуулах хоног - 20
- Цаг уур, нүүдэл, сэлбэгийн хангамжийн saatlaas сул зогсох хоног - 10

Уурхайн цэвэр ажиллах хоног:  $214 - 4 - 20 - 10 = 180$  хоног

- Хоногт ажиллах ээлж – 1
- Ээлжийн үргэлжлэх хугацаа- 8 цаг

**2.3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө**

“Бөхөгийн хөндий” элс-хайрганы холимогийн ордын хөрс хуулалт 25.993 мян.<sup>3</sup>, элс хайрга олборлолт 250.0 мян.м<sup>3</sup> бүтээгдэхүүн гаргалт 248.93 мян.м<sup>3</sup> ил аргаар ашиглахаар 2023 оны төлөвлөгөөнд тусгаж байна.

Хүснэгт №2

	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>Эхний хагас жил</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>Сүүлийн хагас жил</b>	<b>Нийт</b>
<b>Хөрс хуулалт мян.м<sup>3</sup></b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>15</b>	<b>5</b>	<b>5.993</b>				<b>1.28</b>	<b>25.993</b>
<b>Элс хайрга олборлолт мян.м<sup>3</sup></b>		<b>35.0</b>	<b>35.0</b>	<b>70.0</b>	<b>50</b>	<b>50.0</b>	<b>50.0</b>	<b>30.0</b>			<b>250.0</b>

### III. УУРХАЙН ТАЛБАЙГ АШИГЛАХ ДАРААЛАЛ, АШИГЛАЛТЫН СИСТЕМ

#### 3.1. Уурхайн талбайг ашиглах дараалал

Уурхайн талбайн ашиглах дараалалыг элс-хайрганы холимогийн давхаргын тогтоц, уурхайн хил хязгаар дахь хөрс хуулалтын дундаж коэффициентийг баримталж, уулын ажлыг аль болох жигд барьж явуулах, сонгож авсан тоног төхөөрөмжийн жигд ажиллагааг хангах зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн тогтоов.

#### 3.2. Ашиглалтын систем

Элс-хайрганы холимогийн ордын давхаргын тогтооос хамааруулан авто тээвэртэй ашиглалтын системээр уулын ажлыг явуулахаар сонгов.

#### Уулын ажлыг гүйцэтгэх тоног төхөөрөмжийн сонголт

Бөхөгийн элсний ордын тогтоц, чулуулгийн физик механик шинж чанар, уурхайн хүчин чадал, тээвэрлэлтийн зай, болон захиалагчийн санал зэргийг харгалзан үзэж шаардлагатай техник тоног төхөөрөмжийг сонгосон. Үүнд: Хөрс хуулалтад Hyundai фирмийн R-300LC маркын 1.25м<sup>3</sup> утгуурын багтаамжтай гирдовалик экскаватор 1 ширхэг, элс олборлолтод ZL-50 маркын 3м<sup>3</sup> утгуурын багтаамжтай утгуурт ачигч 3 ширхэг, HOWO фирмийн 20 тонн даацтай автосамосвал 7 ширхэг, туслах ажилд Liugong фирмийн B160 маркын бульдозер 1 ширхэгийг тус тус ажиллуулахаар төлөвлөгөөнд тусгалаа.

Хүснэгт 3. Шаардлагатай техник тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Техникийн нэрс	Техникийн марк	I үе шат
1	Эксаватор /1.25м <sup>3</sup> /	Hyundai R-300LC	1
2	Автосамосвал /30тонн/	HOWO	7
3	Бульдозер /3.5м <sup>3</sup> /	Liugong B160	1
4	Утгуурт ачигч /3м <sup>3</sup> /	ZL-50	3

Хүснэгт 4. Автосамосвалын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	HOWO	
1	Хөдөлгүүрийн төрөл		WP10.336	
2	Хөдөлгүүрийн чадал	кВт	340	
3	Даац	Тонн	30	
4	Тэвшний геометр багтаамж	м <sup>3</sup>	15	
5	Урт өргөн өндөр	Метр	5.8*2.3*1.5	
6	Дугуйны харьцаа	Шир	6*4	
7	Өөрийн жин	Тонн	13.5	



### Хүснэгт 5. Liugong B160 маркийн бульдозерын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Liugong B160	
1	Хөдөлгүүрийн төрөл		Weichai	
2	Хөдөлгүүрийн чадал	кВт	120	
3	Бульдозерын урт	Метр	5.03	
4	Бульдозерын өндөр	Метр	3.2	
5	Хусуурын өргөн	Метр	3.4	
6	Хусуурын өндөр	Метр	1.15	
7	Нийт жин	Тонн	17	



### 3.3. Хөрсний овоолго

Бөхөгийн элсний ордыг ашиглах 5 жилийн хугацаанд нийт 13.5 га талбайд 27.05 мян.м³ шимт хөрс хуулахаар байгаа бөгөөд энэ дунджаар 0.2 метр зузаантай шимт хөрс хуулахад 27059 шоо.метр шимт хөрс хуулж хадгалахаар байна. Үүнээс ашиглалтын 1-р жилд хамгийн их буюу 0.37 га талбайд шимт хөрс хуулж овоолго үүсгэхээр төлөвлөсөн.

Хуулсан шимт хөрсийг уурхайн урд хэсэгт 2 метр өндөртэй овоолго үүсгэн, хадгалахаар төлөвлөсөн.

### Хүснэгт 6 .Утгуурт ачигчийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	XCMG ZL-50	
1	Хөдөлгүүрийн төрөл	ShangCha	C6121	
2	Хөдөлгүүрийн чадал	кВт	168	
3	Утгуурт ачигийн урт	метр	8.2	
4	Утгуурт ачигийн өндөр	метр	3.4	
5	Утгуурын өргөн	метр	2.9	
6	Хусуурын өндөр	метр	1.15	
7	Хамгийн бага эргэлтийн радиус	метр	3.42	
8	Утгалт хийх хамгийн их өндөр	метр	1.6	
9	Нийт жин	тонн	17	



### 3.4 Дотоод тээвэр:

Элсний олборлолтод Утгуурт ачигч-Автосамосвалын хослол ашиглах ба автосамосвалууд нь ил уурхайгаас элс угаах үйлдвэр хүртэл 0.7 километр зайд тээвэрлэлт хийхээр байна.

Автосамосвалууд нь ил уурхай байгуулалтын үед зам, далан зэрэг бусад ажилд хэрэглэгдэнэ. Хөрс хуулалт болон элс олборлолтод БНХАУ -д үйлдвэрлэсэн HOWO фирмийн 20 тонн даацтай 7 ширхэг автосамосвал ажиллахад уурхайн хүчин чадлыг хэвийн хангахаар байна.

## IV. ДЭД БҮТЭЦ БА БУСАД ПРОЦЕССУУД

### Технологийн горим

Ил уурхайгаас олборлосон элс хайрганы холимгийг зөөврийн шигших төхөөрөмжөөр шигшин ангилна. Зөөврийн иж бүрэн шигших төхөөрөмж нь туузан дамжуурга, доргиот шигшүүр, бункер зэргээс бүрдэнэ.


Агуулахад хураасан элс хайрганы холимгийг зөөврийн шигших төхөөрөмжийн бункерт

утгуурт ачигчаар өгнө. Бункер нь 100мм хэмжээтэй хөдөлгөөнгүй сараалжин шигшүүрээр тоноглогдсон байна.

Хөдөлгөөнгүй сараалжин шигшүүрийн доорх бүтээгдэхүүндоргиот шигшүүр рүү орно. Доргиот шигшүүрээс  $-5+0$  мм,  $-10+5$  мм,  $-100+10$  мм-ийн ширхэглэлтэй 3 ангиллын бүтээгдэхүүн гарна.

Доорх зурагт шигшин ангилах төхөөрөмжийн схемийг харууллаа.

Хүснэгт 2. Шигшин ангилах технологийн схем



#### 4.1. Уурхайн ундны усны хэрэгцээ

Уурхай ба ангилан ялгах цех нь нүсэр бүтээцгүй улирлын чанартай ажиллах учир уурхай дээр овор бага сэндвичэн барилга байгууламж баригдах ба тусгайлсан дулаан хангамж шаардлагагүй юм. Уурхайн усны хэрэглээ нь ажилчдын унд ахуй, тоосжилт, нөхөн сэргээлт зэрэг болно. Уурхайн усан хангамжыг зөөврийн усаар шийдвэрлэнэ.  
*Уурхайн нохон сэргээлт тоосжилт дараах усны тооцоо*

Уурхай болон замын усалгаанд хэрэглэгдэх усны хангамжийг суманд байрлах ойролцоо гүний худгаас хангана.

#### 4.2. Цахилгаан хангамж

Төслийн талбай Төв аймаг Алтанбулаг сумын төв нь өндөр хүчдэлийн цахилгаан шугам сүлжээнд холбогдсон. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨК-ны салбарт харъяалагддаг байна. Уурхай нь цахилгаан хангамж нь өндөр хүчдэлээс шугам татсан.

### V. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ БА НӨХӨН СЭРГЭЭЛТ

#### 5.1. Байгаль орчныг хамгаалах ба нөхөн сэргээлт

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад тогтоол зааврын дагуу уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа байгууллага нөхөн сэргээлтийн ажлыг Монгол улсын стандарт /MNS5915:2008, MNS5916:2008,

MNS5917:2008 /-ын дагуу заавал хийсэн байх үүрэгтэй.

Нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлуудыг “Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын хамтарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалын хавсралт болох нөхөн сэргээлт хийгдэх ажлын үнэлгээ тооцох аргачлал”-ын дагуу боловсрууллаа. “Доод Бөхөгийн хөндий” элс-хайрганы холимогийн ордын уулын ажлаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх стандартын дагуу доорх ангиллуудад багтана.

## **Б. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын**

Техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд дараах ажлууд хийгдэхээр байна. Үүнд:

- Хөрсний гадаад овоолгыг тэгшлэх, хэлбэржүүлэх, хажууг налуулах болон шимт хөрсөөр бүрэх, суваг шуудуу татах зэрэг ажлууд хийгдэнэ.
- Уурхайн ойр орчмын зам, талбайд үүсэх хөрсний эвдрэл, гэмтлийг тэгшлэх, түрэх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.
- Ашиглагдсан орон зайл нөхөн дүүргэх;
- Ашиглагдсан орон зайл, ухшийг хэвгийжүүлэх, хэлбэршүүлэх;
- Эвдэрсэн газрыг болон овоолгыг тэгшлэх, гадаргууг нь хэлбэржүүлэн тэгшлэх;
- Овоолгын хажууг хэвгийжүүлэн дэвсэгжүүлэх;
- Тэгшилсэн талбайг нягтаршуулах зэрэг хэлбэрээр хийнэ.
- Ачигч ашиглан эвдэрсэн талбайг түрж хэвгийжүүлэх, хэлбэржүүлэх ажлыг, нөхөн дүүргэлтийг автомашинаар зөөж тээвэрлэнэ

## **VI. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

Төслийн ўйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, газрын гүний усан орчин зэрэгт сөргөөр нөлөөлөх нь тогтоогдоо. Иймд төслийг хэрэгжүүлэх үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар доорх зөвлөмжийг өгч байна.

### **6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд дараах арга хэмжээг авна. Үүнд:

**Тоосжилтыг бууруулах:** Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд болон овоолго, уурхайн догол, мөргөцгүүдээс тос, шороо хийсч агаар орчныг бохирдуулдаг, элс хайргыг ачих, тээвэрлэх, буулгах үед үүсэх тоос агаар орчныг бохирдуулахаас гадна ажилчдын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй байдал судалгаанаас харагдаж байна. Иймд эх үүсвэр тус бүр дээр тоосжилт бууруулах арга хэмжээ авах шаардлагатай. Үүнд:

### **Эксаваторын ажлын үед:**

- ~ Ажлын талбай болон мөргөцгийг услах
- ~ Эксаваторын кабиныг битүүмжилж, тоос шүүж агааржуулагч төхөөрөмжөөр тоноглох
- ~ Ээлж тутамд эксаваторын кабиныг чийгтэй алчуураар цэвэрлэж байх

### **Авто зам**

- ~ Бульдозер болон автогрейдерээр уурхайн замыг байнга хусч тоос үүсгэж буй хөрс, чулууг цэвэрлэж байх
- ~ Дулааны улиралд хуурайшилтай үед замыг услах зэргээр тоосжилтыг багасгах
- ~ Олон салаа зам гаргахгүй байх

### **Уурхайн ажлын бус хажуу болон дотоод овоолгод**

- ~ Талбайг услах
- ~ Нөхөн сэргээлт хийх
- ~ Элс хайргыг ачих, тээвэрлэх үед ажиллагсдыг тоосжилтоос хамгаалах хэрэгслээр (амны хаалт) байнга хангах
- ~ Технологийн шаардлага хангахгүй элс хайрга болон бусад төрлийн чулуулаг, бусад хог хаягдлыг уурхайн ашиглагдсан орон зайд буюу овоолгод булж дарах

**Хорт хий бууруулах:** Өмнөх судалгаанаас үзэхэд уурхайн машин, механизмуудын дотоод шаталтатхөдөлгүүрийн яндангаас гарах утаа, хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болж байна.

Хүнд даацын машин, механизмын дотоод шаталтат хөдөлгүүрийн янданд шүүлтүүр тавьж ижил бүрийн техникийн үзлэгээр утаан дахь хорт хийн агууламжийг хянуулах

## **6.2 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах**

Нэгэнт холбогдох газруудаас зохих зөвшөөрлийг нь аваад үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байгаа учир ТЭЗҮ-д тусгасан ордыг ашиглах дарааллыг нарийн чанд мөрдөж ажиллана.. Хөрс хуулалтын ажлыг эхлэхийн өмнө үржил шимт хөрс буюу гадаргаас ойролцоогоор 0.5 м орчим зузаантай хөрсийг бульдозороор 2 тийш түрж овоолгыг ачиж, тээвэрлэн уурхайн зүүн талд 3 метрийн өндөртэй овоолго үүсгэж байршуулах хэрэгтэй. Энэ нь нөхөн сэргээлт хийх ажлын төгсгөлд үржил шимт хөрсөөр буцаан хучих нөхцөлийг хангаж өгдөг.

### **Элс хайрганы хольцын ордын ашиглалтын үндсэн процессууд:**

- ~ Үржил шимт, өнгөн хөрс хуулалтын ажил
- ~ Элс хайрга олборлолтын ажил
- ~ Бутлан ангилах, эцсийн бүтээгдэхүүн гаргах
- ~ Овоолгын тэгшлэлтийн ажил
- ~ Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил зэрэг болно.

Газрын гадарга хөрсийг элэгдлээс хамгаалахын тулд орчиндоо мод, сөөг тарих, олон наст тарих, уурхайн эргэн тойронд хөрсний элэгдлээс хамгаалах өдөр тутмын анхаарал тавих нь зүйтэй.

Эдгээр талбайн хөрс тэнд явуулж буй ажил, үйлчилгээнээс хамааран шингэн, хатуу хог хаягдлаар бохирдох үндэстэй. Зөвхөн уурхайн орчинд буй болох ахуйн хог хаягдлыг тооцож үзэхэд тэнд жорлон, хогийн болон хаягдал тосны сав байх шаардлагатай..

Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа (тосгон, уурхай, шахахуун хадгалах-түгээх цэг, ус татамжийн байгууламж) объектуудад Монгол улсын ариун цэврийн хуулийг мөрдөж ажиллана.

### 6.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- ~ Нөхөн сэргээлтэнд зориулж үржил шимт өнгөн хөрсийг үйлдвэрийн талбайн гадна тусгайлан овоолж бэлтгэх;
- ~ Хөрсний овоолгыг 1 жилээс хэтрүүлэхгүйгээр нөхөн сэргээх ажилд ашиглаж байхаар зохион байгуулах;
- ~ Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалтын MNS 5916 : 2008 стандартыг хэрэгжүүлэх;
- ~ Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн MNS 5917:2008 стандартыг хэрэгжүүлэх;
- ~ Газрын гадаргуугийн хэлбэр дүрсийг анхны төрх байдалд нь ойртуулан засах;
- ~ Хуулан авсан үржил шимт хөрсийг уурхайн талбайн гадна түүний эрэг ирмэгээс доод тал нь 10 м-ээс гадагш зайд 20-иод м-ийн өргөн, 2 м-ээс илүүгүй өндөртэйгээр ордын уртын дагуу чиглэлтэйгээр овоолго хийж хадгалах.
- ~ Мөн ашиглалт хийсэн орон зайд ч хучдас чулуулгийн овоолгыг хийх нь өнгөн хөрсийг эвдэхгүй байх ач холбогдолтой бөгөөд олборлолтын ажлыг явуулах явцад аль болохоор энэ зарчмыг баримтална.
- ~ Хучдас чулуулгийг ихэвчлэн уурхай ирмэгт зайчилсан газарт байрлуулна. Үржил шимт өнгөн хөрсний овоолгыг дахин зөөхгүйгээр тогтвортой хадгалах.
- ~ Үржил шимт өнгөн хөрсийг бульдозероор хуулах ба доод тал нь 20 м, дээд тал нь нэг талдаа 20-40 м зайд түрж тусгай овоолго хийх.
- ~ Энэ ордын өнгөн хөрсийг хуулах ажлыг жил бүрийн оны 5 дугаар сараас эхлэх ба 10 дугаар сар гэхэд олборлох ажлыг зогсоох. Үржил шимт өнгөн хөрсийг хучаас хурдас чулуулгийн овоолготой хольж овоолго хийхийг хориглоно.

### 6.4 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- ~ Хөрс, ус, орчны бохирдлыг багасгахад дүүргийн болон гадаадын төслийн дэмжлэг авч хамтран ажиллана.
- ~ Төсөл хэрэгжүүлэх талбайд гадаргын болон гүний ус байхгүй боловч хур тунадас ба үерийн усаар элс хайрга болон бусад дисперслэг, нарийн ширхэгтэй материал зөөгдөж тархан газрын гадаргыг бохирдуулахаас хамгаалж далан байгуулах, суваг, шуудуу татах.

### 6.5 Ургамлан номрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- ~ Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад орчны төлөв байдалд хяналтын шинжилгээ үе үе хийж байх шаардлагатай.

- ~ Ургамал хөрсний бохирдоор дамжиж гадаргын болон хөрсөн доорхи ус, улмаар хүн, малын ундны ус бохирдох талтайг анхаарах хэрэгтэй.
- ~ Мөн үйлдвэрээс гарах хуурай хог хаягдлыг тогтоосон журмын дагуу зайлцуулж бохирдуулж болох бүх эх үүсвэрийг байнгын хяналтанд байлгавал зохино.
- ~ Үйлдвэрийн орчим сонгож авсан тодорхой цэгдүүдээс хөрсний дээж авч хүнд металлын агууламжийг тодорхой цаг хугацааны зайдай шинжилж дээр тогтоосон хөрсний химийн найрлагыг үндэслэн анхны суурь хэмжээнээс хэр нэмэгдэж буй эсэхийг хянаж байх явдал зайлшгүй чухал.

## 6.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах

Төслийн явцад технологийн дагуу, зүй зохистойгоор ашиглаж, олон салаа зам гаргахгүй, тогтсон нэг чиглэл, замаар техникийг зорчуулах, хуурай болон шингэн хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, шатах тослох материал, барилгын материал түүхий эдийг эмх цэгцтэй хадгалж ашиглах, мөн тайлангаар өгөгдсөн зөвлөмж, байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгож ажиллах, нөхөн сэргээлтийг олборлолтой зэрэгцүүлж явах нь алдагдсан буюу алдагдаж болзошгүй экосистем хуучин төрхдөө ойртох нөхцөлийг бүрдүүлнэ.

## 6.7 Нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

*Төслийн нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд:*

- Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах,
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд нөхцөлд ажиллагсдад нэмэгдэл цалин, урамшуулалт олгох
- Ажилчдын цалинг цаг тухай бүрт нь олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

*Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ*

### *Ажиллах хүчиний тоо, эх үүсвэр*

Уурхайн үйл ажиллагаанд нийт 16 хүн ажиллана. Тус компани ажиллагсдын хөдөлмөр хамгааллын асуудалд анхаарал тавьж зааварчилгаа өгөх, ажлын хувцас, ажлын хамгаалах хэрэгсэл (бээлий, маск, гар багаж г.м)-ээр хангах ариун цэвэр, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлтэй зэрэг жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

### *Нөлөөлөлт өртөгчийн асуудал*

